



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Татан буугдсан хуулийн этгээдийн
хөрөнгийг шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 188 дугаар тогтоолын 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газар татан буугдаж байгаатай холбогдуулан хаалтын тайланд тусгагдсан нийт 851,172,878.42 (найман зуун тавин нэгэн сая нэг зуун далан хоёр мянга найман зуун далан найман төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн болон эргэлтийн хөрөнгийг “Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газарт шилжүүлсүгэй.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ